

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ

Оршил

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу Монгол Улсын Засгийн газраас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулжээ. Эдгээр төслөөс Сангийн яамны цахим хуудсаар дамжуулан олон нийтийн дунд хэлэлцүүлж буй Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төсөлд дүн шинжилгээ хийж, санал шүүмж боловсруулав.

Юуны өмнө худалдан авах ажиллагаанд тулгарч буй тодорхой бэрхшээлүүдийг арилгах, худалдан авах ажиллагаанд шударга, тэгш өрсөлдөөнийг хангах, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн олон шинэлэг заалт хуулийн төсөлд тусгагдсаныг сайшаан дэмжиж байна. Тухайлбал, нэр томъёог нарийвчлан тодорхойлж, худалдан авах ажиллагаанд оролцогчийг хариуцлагатай байлгахад чиглэсэн нийтлэг шаардлага тусган, худалдан авах ажиллагааг зохион байгуулах журмыг нарийвчлан зохицуулсан нь сайшаалтай.

Хэдий тийм боловч худалдан авах ажиллагааны тэгш, шударга өрсөлдөөн, ил тод байдлыг одоогийнхоос илүү сайжруулахад чиглэсэн дараах санал, шүүмжийг иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл, судлаачдын зүгээс гаргаж байна.

Хуулийн төсөлд өгөх санал, шүүмж

- Хуулийн төслийн 35 дугаар зүйлд “Өрсөлдөөнт хэлэлцээний арга”-ыг худалдан авах ажиллагааны шинэ хэлбэр болгон тодорхойлжээ. Энэ нь бараа ажил, үйлчилгээ яаралтай хэрэгцээтэй болсон, гамшиг ослын нөхцөл байдлын улмаас бий болсон хэрэгцээ, шаардлагыг даван туулахтай холбоотойгоор худалдан авах ажиллагааны урилгыг хязгаарлагдмал

хүрээнд тодорхой тооны этгээдэд хүргүүлэн, үнэ хэлэлцүүлэх замаар зохион байгуулах ажиллагаа ажээ. Үүнтэй холбоотойгоор хуулийн төсөлд яаралтай хэрэгцээтэй байдал, түүнийг захиалагч урьдчилан мэдэх боломжгүй байсан, захиалагчийн үйл ажиллагаа удааширнаас шалтгаалаагүй зэрэг нөхцөл байдлыг хэрхэн тодорхойлох, хэн хяналт тавихыг нарийвчлан тодорхойлоогүй байна. Энэ нь төрийн байгууллага яаралтай хэрэгцээ гэх нэрийн дор нээлттэй тендер зарлалгүйгээр худалдан авалт хийх нөхцөлийг үүсгэж байгаа юм. Тиймээс уг хуулийн төсөлд яаралтай хэрэгцээтэй байдал, яаралтай нөхцөл байдлыг нарийвчлан тодорхойлж, хуулийн төслийн 35.4-т заасан “хэлэлцээний тэмдэглэл”-ийг ил тод болгох зохицуулалт нэмж тусгах нь зүйтэй.

- Худалдан авах ажиллагаанд ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, энэ чиглэлээр олон нийтийн хяналт бий болгох үүднээс худалдан авах ажиллагаанд оролцогчийн эцсийн өмчлөгчийн мэдээлэл эсхүл улс төрд нөлөө бүхий этгээд, тэдгээрийн хамаарал бүхий этгээдтэй холбоотой эсэх тухай мэдээллийг авах, ил тод болгох зохицуулалт тусгах.
- Ил тод байдлыг худалдан авах ажиллагааны үндсэн зарчим хэмээн тодорхойлсон байх ч түүнийг хангах үйл явцыг хуулийн төсөлд нарийвчлан журамлаагүй бөгөөд Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай болон Шилэн дансны тухай хуулиудад заасан журмыг баримтлахаар заасан нь хэт ерөнхий байна. Учир нь одоогийн нөхцөлөөр ч худалдан авалтын зарим мэдээллийг Шилэн данс болон Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан нийтэд ил тод болгож байгаа. Шилэн дансанд нийтэлдэггүй тендерийн олон төрлийн мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулж, нийтэд ил тод болгож ирсэн нь олон нийтийн хяналтыг дэмжсэн, олон улсад ч өндрөөр үнэлэгдэх ахиц дэвшил юм. Иймд хуулийн төсөлд худалдан авах ажиллагааны ил тод байдал гэсэн бүлэг шинээр нэмж, уг цахим системийн үйл ажиллагааг хуулиар баталгаажуулах нь зүйтэй. Тус бүлэгт дараах зохицуулалтыг тусгаж болох юм.
- Цахим системээр дамжуулан ил тод болгох мэдээллийн бүрдэл, задаргаа, системд байршуулах хугацааг нэг бүрчлэн тодорхойлох.
- Цахим системд байршуулдаг одоогийн мэдээллээс гадна тендерийн код, худалдан авах гэрээ, гэрээний дүн, хэрэгжилтийн мэдээлэл, үнэлгээний хороо байгуулсан шийдвэр, үнэлгээний хорооны гишүүдийн нэр, албан тушаал зэрэг мэдээллийг нэмж тусгах зохицуулалт оруулах.
- Мэдээллийн сан бүрдүүлэх, үнэн зөв байдлыг хангах ажлыг хариуцах этгээдүүдийн үүрэг, хариуцлагыг тодорхойлох.

- Нээлттэй мэдээллийн стандартыг хангах буюу машинаар унших боломжтой нээлттэй өгөгдөл хэлбэрээр мэдээллийг ил тод болгох шаардлагыг тусгах.
- Цахим систем нь Шилэн данс болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сантай харилцан мэдээлэл солилцох шаардлагыг хуульчлах.

Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой уул уурхайн компанийн худалдан авалтын ил тод байдал судалгааны тайланд Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болон Шилэн дансны мэдээлэл асар их зөрүүтэй байгааг дурджээ.¹ Иймд мэдээллийн зөрүүг арилгах, төрийн худалдан авах ажиллагаанд ил тод байдлыг нэмэгдүүлэх үүднээс Шилэн дансны тухай хуульд дараах өөрчлөлтийг оруулах нь зүйтэй. Үүнд:

- Шилэн дансны тухай хуульд заасан төрийн өмчит хуулийн этгээдийн ангиллыг энэ хуульд нийцүүлэх замаар худалдан авах үйл ажиллагааны ил тод байдлын шаардлагыг бүх төрлийн төрийн өмчит компанид нэг мөр хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.
- Шилэн дансны цахим хуудас нь Төрийн худалдан авах цахим систем, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сантай харилцан мэдээлэл солилцдог байх зохицуулалтыг төсөлд тусгах нь зүйтэй. Ингэснээр Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд орсон анхдагч өгөгдлийг Шилэн дансны цахим хуудаст татаж ашиглах боломж бүрдэн, хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй алдаа, мэдээллийн зөрүү гарахаас сэргийлнэ.
- Шилэн дансанд ханган нийлүүлэгч компанийн регистрийн дугаарыг оруулах шаардлагатай. Компанийн нэр, регистрийн дугаарыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас шууд татаж ашиглах боломжтой бөгөөд ингэснээр хуулийн этгээдийн нэрийг санаатай болон санамсаргүй байдлаар өөр өөрөөр оруулан төөрөгдөл үүсэж буй нөхцөл байдал арилна.
- Нээлттэй мэдээллийн стандартыг хангах буюу машинаар унших боломжтой нээлттэй өгөгдөл хэлбэрээр мэдээллийг ил тод болгох шаардлагыг тусгах.
- Орон нутгийн өмчийн оролцоотой компаниудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоог оновчтой болгон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хэрхэн, ямар давтамжтай хяналт тавих, хяналтын мөрөөр авах арга хэмжээ, түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлэх зохицуулалтыг тусгах нь зүйтэй. Учир нь орон нутагт Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд шат шатны ИТХ хяналт тавих зохицуулалттай боловч хууль хэрэгжсэн

¹ Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой уул уурхайн компанийн худалдан авалтын ил тод байдал судалгааны тайлан, https://forum.mn/res_mat/2021/OSF_CSS%20report%20LAY%20OUT2.pdf

хугацаанд дээр дурдсан судалгаанд хамрагдсан орон нутгийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниудын шилэн дансны үйл ажиллагаанд нь ИТХ-аас хяналт тавьсан тохиолдол байгаагүй байна. Тэрчлэн судалгаанд хамрагдсан орон нутгийн өмчит компаниудаас Тавантолгой ХК-иас бусад нь шилэн данс хөтөлдөггүй болох нь харагдсан юм.

- Түүнчлэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд компанийн дотоод хяналтын нэгж хяналт тавих боломжийг хуульчлах хэрэгтэй. Ингэхдээ дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагаанд компанийн ТУЗ, төрийн хяналтын байгууллага давхар хяналт тавих, тэдгээр хяналтын мэдээллийг нийтэд ил тод болгох тогтолцоог хуульчлах шаардлагатай.
- Шилэн дансны тухай хуулийн хариуцлагын тогтолцоог илүү боловсронгуй болгох хэрэгтэй. Учир нь Шилэн дансны тухай хууль зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр зааснаас уг хуулийн үйлчлэлд хамаарахгүй төрийн өмчит болон орон нутгийн өмчит компани, тэдгээрийн албан тушаалтанд хариуцлага тооцох боломжгүйд хүрээд байна.

Хуулийн шүүмжийг боловсруулсан:
ННФ-ын засаглалын хөтөлбөрийн менежер
Д.Эрдэнэчимэг, хуульч Г.Батнасан.



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Жамъян гүний гудамж-5/1
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар-14240
Монгол Улс
Утас: (976) 76113207
Вэб: www.forum.mn
И-мэйл: osf@forum.mn